



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 06 өдөр

Дугаар A/105

Жаргалтхаан

Хонины цэцэг өвчнөөс урьдчилан  
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дугаар зүйлийн 59.1, 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/275 дугаар тушаал, Хэнтий аймгийн мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/46 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/408 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад сумын нийт хонь, хургыг хамруулах ажлыг 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг тогтоосон хугацаанд шуурхай, чанартай хийж гүйцэтгэхийг гэрээт мал эмнэлгийн нэгжүүдийн захирал, малын эмч нарт үүрэг болгосугай.

3. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг малчид, мал бүхий иргэдэд зарлан мэдээлж, зохих бэлтгэлийг хангуулан хамтран зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд тарилгад хамрагдах малаа бэлэн байлгаж, бүрэн хамруулах, тарилга хийх хашаа хороо бэлтгэн аюулгүй байдлыг ханган ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд даалгасугай.

4. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай тарилгыг татан авч, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тарилгын дүнг нэгтгэн танилцуулж, тайланг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга С.Жавзандуламд үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

232401263